Ховд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2020 онд харьяа орон нутаг дахь 6 сумын 38 төсөвт байгууллага, тусгай сан, аймгийн төвийн 15 төсөвт байгууллага, Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яамны захиалгаар 2 төсөвт байгууллага нийт 55 байгууллага, тусгай сангийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийхээр төлөвлөж гүйцэтгэлээр 5 сумын 32 төсөвт байгууллага, тусгай сан, аймгийн төвийн 17 төсөвт байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийжээ. Дарви сумын төсөвт байгууллага, тусгай сангуудад Ковид-19 цар тахалтай холбоотойгоор хяналт шалгалт хийгдээгүй байна.

Аудитаар 311.5 сая төгрөгийн 254 төлбөрийн акт бичиж 146.8 сая төгрөгийн 5 албан шаардлага өгч, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр өгсөн зөвлөмжийг бүртгээгүй хэрэгжилтийг хянаагүй байна. 2019 онд Санхүүгийн хяналт аудитын алба нь төсөвт байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллахдаа санхүү, нягтлан бодох бүртгэлийг боловсронгуй болгох, санхүүгийн сахилга хариуцлагыг сайжруулах, эрсдэлийг бууруулах талаар ямар нэгэн зөвлөмжийг бүртгээгүй нь Төсвийн тухай хуулийн 69.1¹ дахь заалттай нийцэхгүй байгаад өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдсөн боловч хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Мөн аудитын явцад орон нутгийн байгууллагуудын Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хянахад үр нөлөөтэй үнэн зөв хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Ховд аймгийн ТЕЗ-ийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 16 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 11 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

3.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг нийт орлогын 141480.0 сая төгрөгийн 2 хувь буюу 2829.6 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

3.8 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн

3.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 9794.3 сая, эцсийн үлдэгдэл 10742.2 сая төгрөг болж, 947.9 сая төгрөгөөр буюу 9.6 хувиар өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	0.5	0.4	-0.1
Банканд байгаа бэлэн мөнгө	9793.8	10741.8	948
Дүн	9794.3	10742.2	947.9
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	0		0
Төсөл/ сан	1861.5	2514.6	653.1
Төрийн сан	7888.5	8195.4	306.9
ТӨҮГ болон ОНӨҮГ	44.3	32.2	-12.1
Дүн	9794.3	10742.2	5736.7

¹ Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.

Эх сурвалж: Ховд аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Касст байршиж буй 0.4 сая төгрөг нь ОНӨААТҮГ-ын үлдэгдэл, банканд байршиж буй 10741.8 сая төгрөгийн 2514.6 сая төгрөг нь орон нутгийн тусгай зориулалтын сангийн, 32.2 сая төгрөг нь ОНӨААТҮГ-ын, 8195.4 сая төгрөг нь төрийн сангийн дансанд байршиж байна.

Банканд байгаа мөнгөн хөрөнгө

Банканд байгаа мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 9793.8 сая, эцсийн үлдэгдэл 10741.8 сая төгрөг болж 948.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа мөнгөн хөрөнгө			
Төгрөг			
Төрийн сан	9750	10710	960
Арилжааны банк	43.8	31.8	-12
Нийт дүн	9793.8	10741.8	948

Эх сурвалж: Ховд аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд орон нутгийн төсвийн орлого 110216.7 сая төгрөгөөр бүрдүүлж 81547.4 сая төгрөгийг харьяа байгууллагуудын урсгал санхүүжилтэд, 27082.9 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын санхүүжилтэд, 638.5 сая төгрөгийг СХС-гийн зээлийн санхүүжилтэд зарцуулж оны эцэст 10741.8 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Сумдын СХС оны эцэст 235.4 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй, СХС-гийн зээлээс тайлант онд 606.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 638.5 сая төгрөгийн зээл олгосон, хугацаа хэтэрсэн 3075.0 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлт хангалтгүй, зээлийн эргэц муу,
- Буянт сумын Соёлын төв нь шинэ байр ашиглалтад орсонтой холбоотойгоор 2.3 сая төгрөгийн хандивыг бэлэн мөнгөөр бүрдүүлэн үйл ажиллагаандаа зарцуулсан ч санхүүгийн тайланд тусгаагүй,
- Зэрэг сумын сургууль нь ажлын байрны осол гараагүй байхад хуурамч материал бүрдүүлэн үйлдвэрлэлийн осол тогтоож нэг удаагийн тэтгэмж олгосон гэх иргэдийн мэдээллийг хянахад мэдээлэл нотлогдож, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, захирамж, тушаал шийдвэргүйгээр хүүхдийн хоолны хэмнэгдсэн зардлаас төсөвт төвлөрүүлээгүй нэг удаагийн тэтгэмжид төсвийн тодотгол хийн 57.8 сая төгрөгийг олгосон,
- Зэрэг сумын сургуулийн ойд зориулан хандивын данс нээж 9.9 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн, зарцуулалтын тайлан гаргаагүй данс бүртгэлд тусгаж тайлагнаагүй, байгууллагууд, ажилчдын өгсөн хандивыг хувь харилцах данс руу шилжүүлж хөрөнгө аваагүй
- Жаргалант сумын сургууль, цэцэрлэгүүд цалингийн хэмнэгдсэн зардлаас 188.4 сая төгрөгийг түлшний хөнгөлөлт, үр дүнгийн урамшуулалд олгохдоо үр дүнг нь үнэлэхгүйгээр хавтгайруулан харилцан адилгүй олгосон байна. Тухайлбал: 7-р сургууль 73.0, Цаст-Алтай сургууль 82.0, 6-р сургууль 30.8, 8 дугаар цэцэрлэг 12.5, 14 дүгээр цэцэрлэг 14.6, 10-р цэцэрлэг 7.7 сая төгрөгийг олгосон байхад 11-р цэцэрлэг 0.8 сая төгрөгийг олгосон, .
- Ковид-19 цар тахалтай холбоотойгоор аймгийн төсөвт байгууллагуудад нийт 44.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж санхүүгийн тайланд тусгаж хандивын орлогыг цар тахлын үйл ажиллагаанд зарцуулжээ.
- Шүүхийн шийдвэрээр 2020 онд нийт 16 албан хаагчтай холбоотой 117.1 сая төгрөгийг ажлаас үндэслэлгүйгээр халагдсан төрийн албан хаагчдад ажилгүй байсан хугацааны цалинг урсгал төсвөөс олгожээ.
- ЗГ-аас гаргасан 1999 оны 38 дугаар, 2004 оны 123 тоот тогтоолуудыг зөрчин Цэргийн цолны цалин болон онцгой нөхцөлийн нэмэгдлийг олгоогүй байна.

3.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 9277.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 9275.2 сая төгрөг

болж 2.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	135.7	96.8	-38.9
Төлбөртэй үйлчилгээний авлага	35.4	150.9	115.5
Татаас, санхүүжилтийн авлага	2.3	212.4	210.1
Зээлийн хүүгийн авлага	84.1	98.1	14
Дансны авлага /ТӨҮГ/	320.6	267.5	-53.1
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	3.2	0.6	-2.6
Бусад авлага	3887.4	3587.1	-300.3
Зээлийн авлага	4809.2	4861.8	52.6
Дүн	9277.9	9275.2	-2.7
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	5248.6	1103.1	-4145.5
Төсөл/ сан	2930.8	6929.9	3999.1
Төрийн сан	797.9	971.9	174
ТӨҮГ болон ОНӨҮГ	300.6	270.3	-30.3
Дүн	9277.9	9275.2	-2.7

Эх сурвалж: ТЕЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын илрүүлэлт:

Аудитаар авлага бууруулж ажиллаагүй, өгөгдсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй насжилт өндөртэй 1626.0 сая төгрөгийн зөрчил илэрлээ: Үүнд

- 2018 оны СТА-аар зөвлөмж бичигдэж 2019 оны СТА-аар албан шаардлага өгөгдсөн 1007.8 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй,
- Үйл ажиллагаа нь зогссон “Чандмань БИТ” ОНӨААТҮГ-тай холбоотой 6.2, “Үенч-Эрчим хүч” ОНӨААТҮГ-тай холбоотой 8.5 сая төгрөгийн эзэн холбогдогч нь тодорхойгүй авлагыг данс бүртгэлд тусгасан байна.
- Сумын ИТХ гэсэн нэртэй 6.7 сая төгрөгийн авлагыг данс бүртгэлд тусгасан бөгөөд олон жилийн насжилттай аль сумын ИТХ-аас авах нь тодорхой бус авлага байна.
- 5 жилээс дээш насжилттай 504.2 сая, 4-5 жилийн насжилттай 560.3 сая, 3-4 жилийн насжилттай 447.1 сая, 2-3 жилийн насжилттай 1237.6 сая, 1-2 жилийн насжилттай 1238.8 сая төгрөгийн авлага байгаа нь авлага эргэн төлөгдөхгүй байх эрсдэлтэй байна.
- Орон нутгийн хөрөнгө оруулалтын авлага 461.4 сая төгрөг болж өмнөх оноос 1.8 сая төгрөгөөр бууруулсан нь үр дүн муутай байна.
- ОНХС-гийн авлага өмнөх оноос 88.9 сая төгрөгөөр буурсан байна. Тухайлбал Жаргалант сум 144.3, Буянт сум 10.8 Мянгад сум 4.5, Үенч сум 12.0, Аймгийн ОНХС 203.3 сая төгрөгөөр бууруулан ажиллажээ.
- Булган сум нь ОНХС-гийн хөрөнгийг ажил нь эхлээгүй байхад 110.9 сая төгрөг, Дарви сумын ОНХС-гийн хөрөнгийг ажил нь эхлээгүй байхад 132.5 сая төгрөгийг хувь хүн, ААН-дэд олгож авлагыг нэмэгдүүлсэн байна.
- СХС-гийн зээлийн нийт үлдэгдэл 4861.8 сая төгрөгийн 1377 зээлдэгчтэй холбоотой байгаагаас хугацаа хэтэрсэн 25 зээлдэгчийн 322.3, хэвийн бус 43 зээлдэгчийн 540.7, эргэлзээтэй 91 зээлдэгчийн 863.2, муу 675 зээлдэгчийн 1348.8 нийт 3075.0 сая төгрөгийн зээлийн хугацаа хэтэрсэн байна. СХС-гээс зээл аваад нас барсан 32 иргэн байгаагаас 3 иргэнийн зээлийг бүрэн барагдуулж 29 иргэнтэй холбоотой 107.2 сая төгрөгийн зээлийн үлдэгдэл байна.
- Төсөвт байгууллагын авлага 4145.5 сая төгрөгөөр буурсан ч зарим байгууллагуудад авлага материаллаг дүнгээр нэмэгдсэн байна. Тухайлбал: Чандмань сумын ЗДТГ 93.8 сая, Жаргалант сумын ЗДТГ 61.4 сая, Дарви сумын ЗДТГ 10.5 сая, Дарви сумын ИТХ 10.0 сая, Биеийн тамир спортын газар 12.4 сая, Дуут сумын ЗДТГ 15.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж Үенч сумын ЗДТГ 32.4 сая, 3-р цэцэрлэг 6.4 сая, Буянтын сургууль 6.1 сая, Аймгийн ЗДТГ 8.0 сая төгрөгөөр бууруулан ажиллажээ.
- Аймаг хөгжүүлэх сангийн авлагаас 10 иргэн, ААН-дэд 5.0-30.0 сая төгрөгийн зээл олгосонтой холбоотойгоор 180.0 сая төгрөгөөр авлага нэмэгдэж нийт 1063.0 сая төгрөг

болжээ. Нийт 26 иргэн, ААН-дэд 1063.0 сая төгрөгийн зээл олгохдоо барьцаа хөрөнгө аваагүй, гэрээнд заасан зээл болон зээлийн хүүгийн төлбөрийг төлөөгүйгээс 98.7 сая төгрөгийн орлого бүрдүүлэх эх үүсвэрийг алдсан,

- Агаарын бохирдлыг бууруулах эко барилга барихаар 200.0 сая төгрөгийн зээлийг “Энтү” ХХК-д олгосон боловч тус аж ахуйн нэгж нь барилга бариагүй байна.
- ОНӨААТҮГ-ын авлага 30.3 сая төгрөгөөр буурсан нь “Шим-Ус” ОНӨААТҮГ-ын авлага 56.3 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.8.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 2460.5 сая, эцсийн үлдэгдэл 2118.5 сая төгрөг болж 342.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4 Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын сан	608.6	597	-11.6
Урьдчилж гарсан зардал	1,392.50	1,399.50	7
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	1.8	1.8	0
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	434.5	109.9	-324.6
Цалингийн урьдчилгаа	23.1	10.3	-12.8
Дүн	2,460.50	2,118.50	-342.00
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	434.5	528.3	93.8
Төсөл/ сан	608.6	1588.4	979.8
Төрийн сан	1392.5		-1392.5
ТӨҮГ болон ОНӨҮГ	24.9	1.8	-23.1
Дүн	2460.5	2118.5	-342

Эх сурвалж: ТЕЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын илрүүлэлт:

Аудитаар урьдчилгаа зардал дансанд өмнөх оны албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд авлага бууруулж ажиллаагүй 1.8 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

- 2018 оны СТА-аар зөвлөмж бичигдэж 2019 оны СТА-аар албан шаардлага өгөгдсөн 273.6 сая төгрөгийн урьдчилгааг бууруулан ажиллаагүй байна.
- Үйл ажиллагаа нь зогсоон “Үенч-Эрчим хүч”-тэй холбоотой 1.8 сая төгрөгийн бараа материал бэлтгэх урьдчилгааг данс бүртгэлд тусгасан байна.

3.8.4 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материал оны эхэнд 5052.8 сая, оны эцэст 6210.4 сая төгрөг болж 1157.6 сая төгрөгөөр буюу 22.9 хувиар өссөн байна.

Хүснэгт №5 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	674.0	1,077.6	403.6
Хангамжийн материал	4,288.7	4,896.6	607.9
Нөөцийн бараа	90.1	236.2	146.1
Дүн	5,052.8	6,210.4	1,157.6
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	4,632.3	5,517.9	885.6
Төсөл/ сан	1.5	103.1	101.6
ТӨҮГ болон ОНӨҮГ	419.0	589.5	170.5
Дүн	5,052.8	6,210.4	1,157.6

Эх сурвалж: Ховд аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 6053.3 сая төгрөгөөр худалдан авсан, 497.7 сая төгрөгөөр хандиваар үнэ төлбөргүй, 38.3 сая төгрөгөөр шилжүүлэн авсан, 115.1 сая төгрөгөөр бусад бүгд 6704.4 сая төгрөгөөр нэмэгдэж, 5427.9 сая төгрөгийн бараа материалыг байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан, 17.3 сая төгрөгийг шилжүүлсэн, 16.6 сая төгрөгийг бүтцийн өөрчлөлтөөр, 85.0 сая төгрөгийг бусад нийт 5546.8 сая төгрөгийн бараа материалыг зарцуулжээ.

Тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотойгоор аймгийн төсөвт байгууллагуудад нийт 72.4 сая төгрөгийн маск, хамгаалалтын хувцас хэрэгсэл зэрэг бараа материалыг үнэ төлбөргүй орлогоор хүлээн зөвшөөрч тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

- Аймгийн ЗДТГ-ын нөөцийн бараа 170.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаас 25.6 сая төгрөгийн бараа материал нь нөөцийн барааны шинж чанарын агуулаагүй материалыг бүртгэсэн, тайлант оны эцэст тооллого хийж үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй,
- Жаргалант сумын сургууль, цэцэрлэгүүдийн анги танхимуудын дотоод орчны агаарын чанарыг сайжруулах цэвэршүүлэх, дулааны хэвийн хадгалалтыг дээшлүүлэх алдагдлыг багасгах зорилгоор түлш халаалтын зардлаас аймгийн Засаг даргын А/483 тоот захирамжаар Окфил” ХХК-тай 158.8 сая төгрөгөөр гэрээ байгуулсан, гүйцэтгэлээр 1229 ширхгийг 138.8 сая төгрөгөөр нийлүүлсэн нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн байна.
- Тайлант онд Алтай сумын ЭМТ 1566.3, Буянт ЭМТ 3458.0, Буянт сумын Цэцэрлэг 753.2, Дарви сумын ЭМТ 322.8, Дарви сумын Сургууль 7288.6, Дарви сумын Цэцэрлэг 5482.0, Дуут сумын ЭМТ 332.6, Дуут сумын Цэцэрлэг 3780.8, Зэрэг сумын сургууль 2180.3, Зэрэг сумын ЭМТ 796.6, Манхан сумын Сургууль 3466.3, Манхан сумын Цэцэрлэг 566.2, Дөргөн сумын ЭМТ 249.3, Дөргөн сумын Сургууль 2631.4, Дөргөн сумын Цэцэрлэг 5769.7, Мөнххайрхан сумын Цэцэрлэг 1056.3, Мөнххайрхан сумын Сургууль 4228.0, Үенч сумын Сургууль 1422.1, Жаргалант сумын II цэцэрлэг 234.2, IX цэцэрлэг 736.7, XII цэцэрлэг 2863.0, XIY цэцэрлэг 5069.3 мянган төгрөгөөр өмнөх оноос хүнсний материалыг илүү нөөцөлсөн,
- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Буянт үйлийн шим хоршоо 4.0, Гоёлын ундарга хоршоо 4.0, Хөгжил политехник коллежид 4.0, Цагаан болор нөхөрлөл 1.6, Точма тэмүүжин ХХК 4.0, Микхо ХХК 4.8, Идэр жигүүр ХХК 2.8, Милион бренд ХХК 10.4, Хишигбүрэн 1.0 бүгд 36.7 сая төгрөгийг маск худалдан авах оёж бэлтгэх үйл ажиллагаанд шилжүүлж 43500 ширхэг маскийг аймгийн ЗДТГ-ын эд хариуцагч хүлээн авч 15000 ширхэг маскийг аймгийн ОБГ-т, 28500 ширхэг маскийг Жаргалант сумын 12 багийн айл өрхүүдэд олгож холбогдох анхан шатны баримтуудыг бүрэн бүрдүүлсэн байна.
- Жаргалант сумын сургууль, цэцэрлэгүүдийн хоолны зардлаас аймгийн Засаг даргын А/107 тоот захирамжаар 11680.0 мянган төгрөгөөр 14043 ширхэг маскийг аймгийн ЗДТГ-т хүлээн авч холбогдох зарцуулалтыг хийсэн байна.

3.8.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 215687.7 сая төгрөг, оны эцэст 251806.2 сая болж 36118.5 сая төгрөгөөр буюу 16.7 хувиар өссөн байна.

Хүснэгт №6 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	201,163.6	237,090.2	35,926.6
Биет бус хөрөнгө	14,524.1	14,716.0	191.9
Дүн	215,687.7	251,806.2	36,118.5
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	195,832.9	231,716.8	35,883.9
Төсөл/ сан	1,464.4	1,548.4	84.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	18,390.4	18,541.0	150.6
Дүн	215,687.7	251,806.2	36,118.5

Эх сурвалж: Ховд аймгийн ТЕЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 889.8 сая төгрөгөөр худалдан авсан, 1845.7 сая төгрөгөөр балансаас балансад шилжүүлэн авсан, 12208.0 сая төгрөгөөр үнэ төлбөргүй хандиваар, 22589.5 сая төгрөгөөр бусад нийт 37533.0 сая төгрөгөөр нэмэгдэж, 481.2 сая төгрөгөөр балансаас балансад шилжүүлсэн, 905.6 сая төгрөгийн хөрөнгийг акталсан, 27.8 сая төгрөгийн хөрөнгийг бусад бүгд 1414.6 сая төгрөгөөр хасагдсан байна.

Үндсэн хөрөнгөтэй холбоотой судалгаагаар 28692.3 сая төгрөгөөр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, 410.4 сая төгрөгөөр урсгал төсвөөс, 2438.6 сая төгрөгөөр хандиваар, 2370.9 сая төгрөгөөр шилжүүлэн авсан, 97.1 сая төгрөгөөр үндсэн үйл ажиллагааны болон давсан орлогоос, 3523.7 сая төгрөгөөр бусад нийт 37533.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

хөрөнгийн төрлөөр	нэмэгдсэн					хасагдсан			
	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	Урсгал төсвөөс	Хандив	Дээд шатны болон бусад байгууллагаас шилжүүлэн авсан	Үндсэн үйл ажиллагааны болон давсан орлого	Бусад	Шилжүүлсэн	Акталсан	Бусад
Барилга байгууламж	20,967.4	62.2	596.0	1,795.4	-	1,800.9	1,800.9	202.8	-
Тээврийн хэрэгсэл	75.8	-	235.1	131.4	53.3	218.0	218.0	330.3	20.0
Тоног төхөөрөмж	777.0	214.5	515.0	173.2	5.5	561.9	561.9	168.9	7.6
Тавилга эд хогшил	264.7	65.2	483.0	194.7	19.4	472.7	472.7	152.2	0.3
Зам гүүрийн байгууламж	6,301.5	-	140.1	39.7	18.9	14.2	14.2	-	-
Батлан хамгаалах	-	-	-	-	-	8.3	8.3	-	-
Түүх, соёл, музейн үзмэр	-	-	15.0	-	-	19.1	19.1	0.0	-
Дуусаагүй барилга	-	-	69.9	-	-	114.4	114.4	-	-
Номын фонд	-	19.8	74.9	3.6	-	28.1	28.1	36.6	-
Бусад үндсэн хөрөнгө	305.9	46.3	298.9	32.9	-	278.1	278.1	11.6	-
Программ хангамж	-	0.4	10.7	-	-	2.9	2.9	3.2	-
Биет бус хөрөнгө	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад хөрөнгө	-	2.0	-	-	-	5.0	5.0	-	-
НИЙТ ДҮН	28,692.3	410.4	2,438.6	2,370.9	97.1	3,523.7	3,523.7	905.6	27.8

Аудитын илрүүлэлт:

- Зэрэг сумын Соёлын төвийн хөрөнгөд 8.0 сая төгрөгийг сумын ОНХС-ийн хөрөнгөөр гадна тохижилтын ажилд олгогдож одоог хүртэл уг ажил хийгдээгүй,
- Цэцэг сумын Хөшөөт багыг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотойгоор цэцэрлэгийн барилга, цахилгаан хангамж болон гэрэлтүүлэгтэй холбоотой ажлууд, Соёлын төвийн барилга, халуун ус, гүний худаг, халаалтын зуухны барилга, ус түгээх байр 2, цэвэрлэх байгууламж, гадна инженерийн шугам сүлжээний байгууламж, дээрх барилга байгууламж баригдсан газрыг орлогоод бүртгээгүй байна. Цэцэг сумын Жижиг дунд үйлдвэрлэлийн сангаас авсан тоног төхөөрөмжүүдийг данс бүртгэлд тусгаагүй байна.

3.8.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 4121.9 сая, эцсийн үлдэгдэл 4737.1 сая төгрөг болж, 615.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Богино хугацаат өр төлбөр дүн	4,121.90	4,737.10	615.20
Ажилчидтай холбогдсон өглөг	77.2	73.5	-3.70
Бараа үйлчилгээний зардлын өглөг	43.5	23.9	-19.60
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг		17.9	17.90

Зээлийн хүүгийн өглөг	108.9		-108.90
Бусад өглөг	1327.7	1081.5	-246.20
Урьдчилж орсон орлого	2,564.60	3,540.30	975.70
Урт хугацаат өр төлбөр дүн	943.4	943.4	-
Шим-Ус ОНӨААҮГ	928.4	928.4	-
Чандмань БИТ	15	15	-
Нийт дүн	5,065.30	5,680.50	615.20
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	237.6	187.1	-50.5
Төсөл, сан	76.6	201.6	125
Төрийн сан	3360.8	4078.3	717.5
ТӨҮГ болон ОНӨҮГ	1390.3	1213.5	-176.8
ДҮН	5065.3	5680.5	615.2

Эх сурвалж: ТЕЗ.-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөр 4737.1 мянган төгрөг болж өмнөх оноос 615.2 мянган төгрөгөөр өсөхөд барьцаа данс 975.7 сая төгрөгөөр өсөж бусад өр төлбөрүүд 360.5 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Төсөвт байгууллагын өглөг 187.1 сая төгрөг болж өмнөх 50.5 сая төгрөгөөр буурчээ. Тухайлбал: Буянт сумын сургууль 6.9 сая, Дуут сумын хүн эмнэлэг 4.3 сая, Жаргалант сумын 1 дүгээр сургууль 11.8, Зэрэг сумын ЗДТГ 7.2 сая, Мөнххайрхан сумын ЭМТ 6.1 сая, Мянгад сумын ЭМТ 6.8 сая, Мөст сумын сургууль 15.2 сая, Хөгжимт драмын театр 5.0 сая, Чандмань сумын ЭМТ 5.9 сая, Үенч сумын сургууль 12.3 сая, Үенч сумын ЭМТ 7.3 сая төгрөгөөр бууруулан ажиллажээ. Мөн өглөгийг материаллаг дүнгээр дараах байгууллагууд нэмэгдүүлсэн байна. Үүнд: Биеийн тамир спортын газар 65.9 сая, Жаргалант сумын ЗДТГ 16.1 сая, Хот тохижуулах газар 8.2 сая, Мөст сумын ЗДТГ 4.3 сая, Орон нутгийн өмчийн газар 20.0 сая, Санхүүгийн хяналт аудитын алба 4.6 сая төгрөгийн өр төлбөрийг нэмэгдүүлжээ.

Төсөл сангийн өглөгийг эцсийн үлдэгдэл 201.6 сая төгрөг болж 125.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Дарви сумын ОНХС нь тайлант онд бүрэн дуусаагүй хөрөнгө оруулалтын ажлуудын олгогдоогүй үлдэгдлийг 124.5 сая төгрөгөөр өр төлбөрт бүртгэсэнтэй холбоотой байна. Төрийн сангийн өглөгийн эцсийн үлдэгдэл 4078.3 сая төгрөг болж өмнөх оноос 717.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Орон нутгийн ерөнхий орлого дансны өр төлбөр 325.1 сая төгрөгөөр буурч Техник хяналтын барьцаа дансны өглөг 975.1 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

ОНӨҮГ-ын өр төлбөрийн эцсийн үлдэгдэл 1213.5 сая төгрөг болж өмнөх оноос 176.8 сая төгрөгөөр буурсан байна. “Шим-Ус” ОНӨААТҮГ нь 242.1 сая, “Минжит булган” хот тохижуулах газар 10.0 сая, “Тээлийн-Илч” ОНӨААТҮГ нь 5.6 сая төгрөгөөр өр төлбөрийг бууруулан ажиллаж “Мянган-Угалзат” ОНӨААТҮГ нь 29.6 сая төгрөгөөр өр төлбөрийг нэмэгдүүлжээ.

Барьцаа дансанд хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэлийн баталгаа 3540.3 сая төгрөг байршуулж өглөгөө бүртгэсэн тул дараагийн онд барагдах боломжтой өглөг байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд Шим-Ус ОНӨААТҮГ-ын 928.3 сая төгрөгийн өр нь аймаг, орон нутагт гэр хорооллын ус цэвэрлэх байгууламжийг сэргээн засварлах, газар доорх ус хангамж, ариутгалын систем, дэд бүтцийн тоног төхөөрөмжийг шинэчилж сайжруулах, гэр хорооллын зарим газруудыг төвлөрсөн системд холбож худаг гаргах, Чандмань сумын БИТ төвийг 15.0 сая төгрөгөөр барихад зориулан нийт 943.4 сая төгрөгийн зээл олгогдсон байна.

Аудитын илрүүлэлт:

- Төсвийн төлөвлөлт болон дотоод хяналт сул, Ковид-19 цар тахалтай холбоотойгоор зарим байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөө тасарснаас шалтгаалан Биеийн тамир спортын газар 65.9 сая, Хот тохижуулах газар 8.2 сая, Мөст сумын ЗДТГ 4.3 сая, Орон нутгийн өмчийн газар 20.0 сая, Санхүүгийн хяналт аудитын алба 4.6 сая төгрөгийн өр төлбөрийг нэмэгдүүлжээ.

- Үйл ажиллагаа нь зогссон “Үенч-Эрчим хүч” ОНӨААТҮГ-ын 9.3 сая төгрөгийн өр төлбөрийг данс бүртгэлд тусгасан байна.

3.8.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 171732.7 сая, эцсийн үлдэгдэл 190937.0 сая төгрөг болж 19204.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №8 Нийт засгийн газрын оруулсан капиталын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/ бууралт /-/
Засгийн газрын оруулсан капитал	92,580.80	92,697.50	116.70
Хуримтлагдсан үр дүн	44,090.60	71,371.80	27,281.20
Дахин үнэлгээний нэмэгдэл	54,265.60	54,185.14	-80.46
Дүн	190,937.00	218,254.44	27,317.44
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	181,962.90	208,024.34	26,061.44
ТӨҮГ болон ОНӨҮГ	<u>8,974.10</u>	<u>10,230.10</u>	1,256.00
Дүн	190,937.00	218,254.44	27,317.44

Эх сурвалж: Ховд аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал

Эмийн эргэлтийн сангийн хөрөнгийг данс бүртгэлд шинээр тусгасантай холбоотойгоор 21.4 сая төгрөг, “Үенч Мөнх-Ундарга баялаг” ОНӨААТҮГ шинээр нээгдсэнтэй холбоотой 5.0 сая төгрөгийн эздийн өмчийг данс бүртгэлд тусгасан байна. “Шим-Ус” ОНӨААТҮГ нь үнэ төлбөргүй ирсэн 95.3 сая төгрөгийн хөрөнгө, “Тээлийн илч” ОНӨААТҮГ нь 3.0 сая төгрөгийн үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгасантай холбоотойгоор Засгийн газрын оруулсан капитал нийт 124.7 сая төгрөгөөр нэмэгджээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөр 15 байгууллагатай холбоотой үндсэн хөрөнгийн хөрөнгийн дахин үнэлгээ дансыг 80.5 сая төгрөгөөр бууруулах бичилт хийж 33 байгууллагатай холбоотой 31.3 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдлийн зөрүү болон авлага, өр төлбөрийн зөрүүг өмнөх үеийн үр дүн дансанд залруулсантай холбоотойгоор өмнөх үеийн үр дүн данс буурсан байна. Тайлант үеийн үр дүн 27394.0 сая төгрөгөөр хуримтлагдсан үр дүнг өсгөсөн байна.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 159 төсвийн байгууллага, 12 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 36 тусгай сан, 18 төрийн сан нийт 220 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 202 байгууллага аудитад хамрагдсан, 18 байгууллага аудитад хамрагдаагүй байна. Үенч-Эрчим хүч, Чандмань Бит, Эв зөийн хүч ОНӨААТҮГ-ууд нь үйл ажиллагаа явуулдаггүй тул хамрагдаагүй байна. Бусад байгууллагууд нь Аймаг засаг даргын дэргэд байдаг данснууд тул аудитад хамруулаагүй байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 58 байгууллагыг түүвэрт хамруулж, 144 байгууллагад дүгнэлт хүргүүллээ. Үүнд: “Зөрчилгүй” 100 “Хязгаарлалттай” 41 /Цэцэг, Манхан, Үенч, Мөст, Чандмань сумдын цэцэрлэгүүд, Цэцэг, Алтай Дөргөн, Эрдэнэбүрэн, Дарви, Жаргалант сумын ЗДТГ-ууд, Мянгад, Алтай, Эрдэнэбүрэн, Цэцэг, Дөргөн сумдын ЭМТ-үүд, Булган сумын 1, 2 Мөнххайрхан, Мөст, Чандмань, Эрдэнэбүрэн, Үенч, Дарви

сумдын сургуулиуд, Цэцэг, Дуут сумдын соёлын төвүүд, Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газар, Булган сумын насан туршийн боловсрол, Санхүүгийн хяналт, аудитын алба, Гэр бүл хүүхэд залуучуудын газар, Орон нутгийн өмчийн газар, Биеийн тамир спортын газар, Нийтийн номын сан, Манхан, Булган, Үенч, Дарви, Зэрэг, Мөнххайрхан, Мөст сумдын ТТЗ-ууд, “Мянган-Угалзат” ОНӨААТҮГ /, “Сөрөг” 2 /Зэрэг сумын сургууль, Цэцэг сумын ТТЗ/ “Татгалзсан 1” /“Үенч Мөнх-Ундарга” ОНӨААТҮГ/ санал дүгнэлт өгсөн байна.

Ховд аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 1925.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 15.0 сая төгрөгийн 1 алдааг залруулж 200.0 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 1710.5 сая төгрөгийн алдаа, зөрчилд 12 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар “Сөрөг”, “Татгалзсан” санал дүгнэлт авсан 3 төсвийн захирагч, нягтлан бодогч нарт хариуцлага тооцуулах албан шаардлагыг хүргүүлэн ажиллаа.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Ховд аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайланд 15.0 сая төгрөгийн Буянт сумын Соёлын төвд хандиваар ирсэн түүх дурсгалын зүйлийг тавилга эд хогшилд ангилал буруу бүртгэснийг аудитын явцад залрууллаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн албан шаардлага

1. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр эко орон сууц барих төсөл бичиж 200.0 сая төгрөгийн зээлийг “Энтү” ХХК-д олгосон боловч одоог хүртэл орон сууцаа бариагүй байна. Энэ нь гэрээний 1.3-д “Гэрээний төсөл хэрэгжүүлэгч бизнес төлөвлөгөөнд заасан ажил үүргийг гүйцэтгэнэ”, 5.2.1-д “Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг зээлдэгчээс шаардах, 6.1-д “Зээлдэгч нь хүлээсэн үүргээ гэрээнд заасан хугацаанд биелүүлээгүй тохиолдолд учирсан бүхий л хохирол, зардлыг нөхөн төлнө” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Буцаан төвлөрүүлэх албан шаардлага өгөх

2. Төсвийн тухай хуулийн 6.4.1, 6.4.8, 8.9.1, 8.9.2, 26.1, 41.2, 46.1.6, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.1, 7.7, 10.3, 13.7, 12.2.1, 14.4.2, 20.1.4, 20.2.12, 20.2.5, 20.2.6, Татвар, Шилэн данс, Нийгмийн даатгалын тухай хуулиудын холбогдох заалтуудыг зөрчсөнөөс санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэж 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Сөрөг”, “Татгалзсан” санал дүгнэлт авсан 3 байгууллагын төсвийн захирагч нягтлан бодогч нарт нь хариуцлага тооцон ажиллах

Шийдвэрлэсэн: “Сөрөг”, “Татгалзсан” дүгнэлт авсан байгууллагын төсвийн захирагч, нягтлан бодогч нарт хариуцлага тооцуулах албан шаардлага өгөх

3. Шилэн дансны нэгдсэн сайтын худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан зэрэг цэсийг огт хөтлөөгүйгээс тухайн мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ.”, ЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан журмын холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага өгөх

Төсвийн ерөнхийлөн захирагчид 1710.5 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 12 зөвлөмжийг аудитын тайланд дурдсан болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Харьяа ТТЗ-ийн 17 байгууллагаас “Зөрчилгүй” 9, “Хязгаарлалттай” 7 / Манхан, Булган, Үенч, Дарви, Зэрэг, Мөнххайрхан, Мөст/ “Сөрөг” 1 /Цэцэг/ санал дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 7688.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 303.9 сая төгрөгийн 16 алдааг залруулж, 39.2 сая төгрөгийн зөрчилд 8 төлбөрийн акт тогтоож, 2851.2 сая төгрөгийн зөрчилд 18 албан шаардлага, 4483.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд 58 зөвлөмж өгч 10.0 сая төгрөгийн 2 хариуцлага тооцуулах албан шаардлага өглөө.

Төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төсвийн байгууллагаас 23 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, “Зөрчилгүй” 83, “Хязгаарлалттай” 33 /Цэцэг, Манхан, Үенч, Мөст, Чандмань сумдын цэцэрлэгүүд, Цэцэг, Алтай Дөргөн, Эрдэнэбүрэн, Дарви, Жаргалант сумын ЗДТГ-ууд, Мянгад, Алтай, Эрдэнэбүрэн, Цэцэг, Дөргөн сумдын ЭМТ-үүд, Булган сумын 1, 2 Мөнххайрхан, Мөст, Чандмань, Эрдэнэбүрэн, Үенч, Дарви сумдын сургуулиуд, Цэцэг, Дуут сумдын соёлын төвүүд, Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газар, Булган сумын насан туршийн боловсрол, Санхүүгийн хяналт, аудитын алба, Гэр бүл хүүхэд залуучуудын газар, Орон нутгийн өмчийн газар, Биеийн тамир спортын газар, Нийтийн номын сан/, “Сөрөг” 1 /Зэрэг сумын сургууль/ дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 7774.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2930.4 сая төгрөгийн 157 алдааг залруулж, 163.2 сая төгрөгийн зөрчилд 51 төлбөрийн акт тогтоож, 2175,9 сая төгрөгийн зөрчилд 38 албан шаардлага, 2504.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд 296 зөвлөмж, 1.0 сая төгрөгийн 2 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага өглөө.

Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төрийн болон орон нутгийн өмчит 9 аж ахуйн нэгж байгууллагаас “Зөрчилгүй” 7, “Хязгаарлалттай” 1 /“Мянган-Угалзат” ОНӨААТҮГ/, “Сөрөг” 1 /Үенч Мөнх-Ундарга ОНӨААТҮГ/ дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 50.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 10.4 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 1.9 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 37.9 сая төгрөгийн алдаа, зөрчилд 11 зөвлөмж өглөө.

Аудитын илрүүлэлт:

- Тээлийн-Илч, Зэрэг Шим-Ус, Минжит булган хот тохижуулах газар, Үенч Мөнх-Ундарга ОНӨААТҮГ нь төлөөлөн удирдах зөвлөлөө батлуулаагүй, жилийн орлогын доод хязгаар болон зардлын дээд хязгаар, орон тоог батлуулаагүй байна.

Орон нутгийн түсгай санд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа 36 тусгай 35 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, “Зөрчилгүй” 1 дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 15.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 15.0 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 1 алдаа, зөрчилд зөвлөмж өглөө.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 15527.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 3244.6 сая төгрөгийн 174 алдааг залруулж, 219.3 сая төгрөгийн зөрчилд 61 төлбөрийн акт тогтоож, 5027.1 сая төгрөгийн зөрчилд 56 албан шаардлага, 7025.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд 366 зөвлөмж, 10.9 сая төгрөгийн зөрчилд 4 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага өглөө. Санхүүгийн тайлангийн аудитаар, “Сөрөг”, “Татгалзсан” санал дүгнэлт авсан нийт 3 байгууллагын төсвийн захирагч,

нягтлан бодогч нарт хариуцлага тооцуулах албан шаардлагыг Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлээ.

3.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Аудитын багийн хүний нөөц, цаг хугацааны асуудлаас шалтгаалан Нэгдсэн удирдамжаар Улсын төсвийн хөрөнгө оруулалтын аудит хийгдэж байгаа, Орон нутгийн хөрөнгө оруулалтын хөрөнгийн зарцуулалтад 8 сард аудит хийх төлөвлөгөөтэй байгаа тул ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл, хөрөнгийн зарцуулалтыг тус аудитаар хамтад нь хянахаар тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

3.11. Шилэн дансны мэдээлэл

Ховд аймгийн ТЕЗ-ийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 62 мэдээллийг хугацаанд нь, 56 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 32 мэдээллийг байршуулаагүй байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Тендерийн ерөнхий мэдээлэл, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан зэргийг мэдээлээгүй байна.

Аймгийн ТЕЗ-ын эрхлэх асуудлын хүрээний 134 байгууллагыг хамруулж түүвэрлэн хяналт хийхэд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан тогтмол мэдээлэх мэдээллийг 92.0 хувь болж өмнөх оноос 15.3 хувь өссөн байгаа боловч дараа жилийн төсвийн төсөл, хагас жилийн санхүүгийн тайлан, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан зэрэг мэдээллүүдийг мэдээлэлт өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээнд байгууллагын санхүүжилтийн мэдээллийг, мөн байгууллагын нэмэлт дансны орлого зарлагын мэдээллийг мэдээлж хэвшихгүй байна.

Түүвэрт хамрагдсан 134 байгууллагын дансны хуулга боловсруулж шалгахад мэдээлсэн гүйлгээнүүдээс мэдээлээгүй гүйлгээнүүд их гарч байгаад анхаарах шаардлагатай байна.

3.12. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР ТОДОРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид өгсөн 1281.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлснээс хариуцлага тооцуулах албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллаж 382.4 сая төгрөгийн 4 авлагыг хуулийн байгууллагад шилжүүлэн шалгагдаж байна. Ковид-19 цар тахалтай холбоотойгоор ААН-дийн үйл ажиллагаа доголдсонтой холбоотойгоор авлага болон урьдчилгааг төлүүлэх ажлыг түр хойшлуулсан байна.

Нийт 12 зөвлөмж өгснөөс 6 зөвлөмжийг хэрэгжүүлж, 5 зөвлөмж хэрэгжих шатанд, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй буюу зөвлөмжийн хэрэгжилт 70 хувьтай байна. Хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал:

д/д	Өгсөн зөвлөмж	Биелэлт	Хувь
1	Цар тахалтай холбоотойгоор амархан муудах хүнсний бүтээгдэхүүнийг муудахаас нь өмнө арга хэмжээ аван ажиллах	Аймгийн Засаг даргын 4/488 тоот албан бичгээр хүнсний бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэгчдэд буцаан олгож сургууль цэцэрлэгийн үйл ажиллагаа эхлэхээр буцаан авах зохицуулалт хийн хүнсний хорогдол гаргаагүй байна.	100

Ховд аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2	Төсвийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль зөрчин Дарви сумын ЗДТГ нь санхүүгийн түрээсийн гэрээ байгуулсан зөрчилд дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллах	Санхүүгийн түрээсийн гэрээг цуцалж сумын өөрийн санхүүгийн эх үүсвэрээр худалдан авах гэрээ болгон өөрчилсөн	100
3	Холбогдох хуулийн дагуу төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагааг ард иргэд, ААН-дийг мэдээллээр ханган ажиллах	2020 оны УТХО-аар 22.8 тэрбум төгрөгийн 46 төсөл, хөтөлбөрийг хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж ОНХО-таар 9.7 тэрбум төгрөгийн 153 төсөл арга хэмжээний худалдан авалтыг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 106 төсөл арга хэмжээг сум байгууллагад эрх шилжүүлэн 47 төсөл хөтөлбөрийн худалдан авалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж шилэн дансанд байршуулан ил тод байдлыг ханган ажиллаа.	100
4	Аймгийн эрүүл мэнд, боловсролын салбарт хөрөнгө оруулалтаар ирсэн тоног төхөөрөмжийн хуваарилалтыг дахин хянаж хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэн ажиллах	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ирсэн тоног төхөөрөмжийн олголтод хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж боловсролын салбарын хөрөнгө оруулалтаас дутагдсан хөрөнгүүдийг холбогдох байгууллагуудад нь буцаан олгосон.	100
5	Санхүүгийн хяналт, аудитын алба нь тайлант онд нягтлан бодох бүртгэлийг сайжруулах, төсвийн хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлэхээр өгсөн зөвлөмжийг хяналт хийсэн байгууллагуудаар бүртгэж хэрэгжилтийг хянан дотоод аудитын албаны ажлыг сайжруулан ажиллах	Санхүүгийн хяналт аудитын алба нь тайлант онд 311.5 сая төгрөгийн төлбөрийн акт бичиж 146.8 сая төгрөгийн албан шаардлага бичсэн байна. Хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлэх, бүртгэлийг сайжруулах талаар зөвлөмж өгөөгүй байна.	20
6	Сумдын сургуулийн нягтлан бодогч нар нь цэцэрлэгийн нягтлан бодогчийн ажлыг хавсран гүйцэтгэж байгаа нь ажлын ачааллыг нэмэгдүүлж байгааг анхаарч төсвийн хүрээнд зохицуулалт хийж сургуулийн нягтлан бодогчийн ачааллыг бууруулан ажиллах	2020 оноос Жаргалант сумын 8 цэцэрлэгийг тусдаа нягтлан бодогч, няравтай болгож Цэцэг сумын цэцэрлэгийг тусдаа нягтлан бодогчтой болгосон. Засгийн газраас цар тахлын үед төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлсэнтэй холбоотойгоор орон тоог нэмэгдүүлэхийг хязгаарласан тул хэрэгжүүлэх ажиллагаа хойшилсон болно. Цаашид эхэлсэн бодлогыг үргэлжлүүлэн хамгийн олон анги бүлэгтэй, хүүхэд хамрагдалт ихтэй сумын цэцэрлэгээс эхлэн нягтлан бодогчтой болгох ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	50
7	Элэгдлээрээ өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжгүй 43 байгууллагын 26.9 сая төгрөгийн санхүүгийн программ хангамжийг данс бүртгэлээс хасах асуудлыг шийдвэрлэн ажиллах	Ашиглалтын хугацаа дуусаагүй байгаа тул данснаас хасах боломжгүй гэж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаас шийдвэрлэсэн тул хүлээгдэж байна.	50
8	Чандмань сумын ЭМТ-ийн 958.8 сая төгрөгийн өртөг бүхий барилгыг ланс бүртгэлд тусгах тогтоолыг гаргуулан ажиллах	Чандмань сумын ЭМТ-ийн 958.8 сая төгрөгийн өртөг бүхий 3500 м.кв барилгыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 102 тоот тогтоолоор данс бүртгэлд тусгуулан ажилласан	100
9	Мянган-Угалзат ОНӨААТҮГ-ын данс бүртгэлд байгаа 19.4 сая төгрөгийн халаалтын тогоог Жаргалант сумын 7-р сургуульд шилжүүлэх шийдвэр гаргуулан ажиллах	Үлдэх өртөгтэй тул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар данснаас хасах боломжгүй гэсэн шийдвэр гарсан.	0
10	Батлагдсан төсвийг журнал ваучераар холбогдох эрхийн актгүйгээр бусад байгууллагад шилжүүлдэг явдлыг таслан зогсоох	Тайлант онд журнал ваучераар холбогдох эрхийн актгүйгээр бусад байгууллагад шилжүүлэг хийгдээгүй	100
11	Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж шийдвэрлэгдэхгүй олон жил болсон 618.3 сая төгрөгийн өр төлбөрийг шийдвэрлэн ажиллах	2020 онд цалинтай холбоотой авлага, өглөг үүсгээгүй бөгөөд өмнөх онд үүссэн 20.5 сая, хувь хүнд өгөх өглөгийг 10.5 сая, дансны өглөг 100.8 сая нийт 131.8 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулан ажиллаж үлдэгдэл бүх өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулсан.	80
12	Аймгийн төсвийн шууд захирагч нарт чиглэл хүргүүлэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр	Сум байгууллагуудад 2020 оны 7 дугаар сарын 1-ны өдрийн Зөвлөмж хүргүүлэх тухай 5/1060 албан бичиг, 2020-12-17-ны өдрийн 5/2008 дугаар албан	20

тогтоолын 7-д “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох тухай” гэсэн заалтыг мөрдөж ажиллах

бичиг, 2021-01-21-ны өдрийн 5/191 албан бичгээр хэрэгжилтийг хангах тухай мэдэгдэж арга хэмжээ авч ажилласан. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 86 дугаар тогтоолд “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, худалдах, акталж устгах, данснаас хасах, тайлагнах журам”-д өөрчлөлт оруулахаар тогтоолын төсөл бэлдэж Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол гаргуулахаар ажиллаж байгаа бөгөөд шийдвэр гарснаар 2021 оноос хэрэгжинэ.

Нийт дүн

70

3.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Ховд аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Зөрчилгүй дүгнэлт

Залруулагдаагүй 1910.5 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 2829.6 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага тул Зөрчилгүй дүгнэлтийг өгч байна.

Ховд аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3.14. Аудитын зөвлөмж

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД:

- Аймаг хөгжүүлэх сан, агаарын бохирдлыг бууруулах төсөл хөтөлбөрөөс зээл авсан зээлдэгчдээс үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг барьцаа болгон авч барьцаа хөрөнгийн гэрчилгээг эх хувиар нь авч барьцаалах, зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж ажиллах
- Булган, Дарви, Зэрэг сумдад дотоод хяналтын баг томилон ажиллуулж, төсвийн хөрөнгө зарцуулалтад хяналт хийх,
- Аймгийн санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгагдсан татан буугдсан аж ахуйн нэгж болон эзэн холбогдогч нь тодорхой бус авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, урьдчилгаа, өр төлбөр данстуудад ажлын хэсэг байгуулан ажиллаж хуулийн дагуу шийдвэрлэх
- СХС-гийн хөрөнгийг эргэцийг сайжруулах, зээлдэгчдийн мэдээллийг холбогдох байгууллагуудтай хамтран Монгол банкны зээлийн мэдээллийн санд бүрэн оруулах ажлыг зохион байгуулах
- ТБОНӨХБАҮХАТХ-ийн холбогдох заалтуудыг баримтлан ажиллаж төсвийн хөрөнгийг үр өгөөжийг нэмэгдүүлэн ажиллах
- Төрийн албаны тухай хууль болон Зөрчлийн тухай хуульд заасны дагуу Төрийн албаны зөвлөл болон санхүүгийн хяналт, дотоод аудитаар хяналт хэрэгжүүлэн буруутай албан тушаалтнаар буцаан төлүүлэх арга хэмжээг авч ажиллах

- Цэргийн штабын албан хаагчдын цэргийн цолны цалин болон удаан жилийн нэмэгдлийг Засгийн газрын тогтоолын дагуу олгож хэвших, онцгой нөхцөлийн нэмэгдлийг Төрийн албаны зөвлөлөөр шийдвэрлэн ажиллах

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГАД:

- Цэцэг сумын Хөшөөт багыг нүүлгэн шилжүүлсэнтэй холбоотойгоор хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлууд, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас бэлтгэгдсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгуулах
- “Чандмань БИТ”, “Үенч-Эрчим хүч” ОНӨААТҮГ-д нь үйл ажиллагаа явуулахгүй байгаатай холбогдуулан дээрх байгууллагуудын хөрөнгө, авлага, өр төлбөрийн асуудлыг шийдвэрлэн татан буулгах ажлыг зохион байгуулах
- Зэрэг Шим-Ус, Зэрэг Тээлийн-Илч, Минжит булган хот тохижуулах газар, Үенч Мөнх-Ундарга ОНӨААТҮГ-д нь төлөөлөн удирдах зөвлөлгүй, орлогын доод хязгаар, зардлын дээд хязгаар, орон тоог батлуулан ажиллаагүй байгаа тул сумдын ИТХ-аар ТУЗ-ыг батлуулан ажиллах

САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГАД:

- Байгууллагууд хандив цуглуулахтай холбоотой ажлуудыг нэмэлт дансаар дамжуулан зарцуулах эрхийг нээн өгч хандивын орлого, зардлыг санхүүгийн тайланд бүрэн тусгуулан ажиллах
- Сургууль, цэцэрлэгүүдийн цалингийн сангийн зарцуулалтад хуулийн дагуу төрийн сангийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллах

Аудитаар өгсөн акт, албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 10 дугаар сарын 1-ны дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлэх

5. 4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Ховд аймгийн ТЕЗ-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			XOA-2021/01/СТА-ТЕЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Ховд аймгийн Засаг дарга		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөрөөс "Энтү" ХХК нь агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр эко орон сууц барихаар 200.0 сая төгрөгийн зээлийг	200,0	Албан шаардлага	Засаг дарга, Санхүү төрийн	Б.Дүгэржав Ч.Багдал

	2019 онд авсан боловч одоог хүртэл орон сууцаа барьж байгуулаагүй байна.			сангийн хэлтсийн дарга
2	Аймгийн ТЕЗ-ын эрхлэх асуудлын хүрээний аймгийн ОНХС, ОНХО, УТХО, ЗД зэрэг данснуудын шилэн дансны хуулийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй	0	Албан шаардлага	
3	Аймгийн ТЕЗ-ын нэгтгэлд хамрагдаж дүгнэлт авсан байгууллагуудаас 2 байгууллага "Сөрөг", 1 байгууллага "Татгалзсан" санал дүгнэлт авсан байна.	0	Албан шаардлага	
4	Үйл ажиллагаа нь зогссон "Чандмань БИТ" ОНӨААТҮГ-тай холбоотой 6.2, "Үенч-Эрчим хүч" ОНӨААТҮГ-тай холбоотой 8.5 сая төгрөгийн эзэн холбогдогч нь тодорхойгүй авлагыг данс бүртгэлд тусгасан, Сумын ИТХ гэсэн нэртэй 6.7 сая төгрөгийн авлагыг данс бүртгэлд тусгасан бөгөөд олон жилийн насжилттай аль сумын ИТХ-аас авах нь тодорхой бус авлага, Булган, Дарви сумд нь ОНХС-гийн хөрөнгийг ажил нь эхлээгүй байхад ААН, иргэдэд нийт 243.4 сая төгрөгийг шилжүүлэн авлагаар бүртгэсэн, Аймаг хөгжүүлэх сан болон агаарын бохирдол бууруулах төсөл хөтөлбөрөөс 1063.0 сая төгрөгийн зээл олгосон боловч барьцаа хөрөнгө аваагүй, зээлийн гэрээнд заагдсан зээлийн хүү болон эргэн төлөлтөө хийгээгүйтэй холбоотой 98.7 сая төгрөгийн орлого орох боломжийг алдсан байна.	1426.5	Зөвлөмж өгөх	
5	Үйл ажиллагаа нь зогссон "Үенч-Эрчим хүч" ОНӨААТҮГ-ын бараа материал бэлтгэх урьдчилгаа байна.	1.8	Зөвлөмж өгөх	
6	Сумдын СХС оны эцэст 235.4 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй, СХС-гийн зээлээс тайлант онд 606.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 638.5 сая төгрөгийн зээл олгосон, хугацаа хэтэрсэн 3075.0 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлт хангалтгүй байгаа нь зээлийн эргэц хангалтгүй удаашралттай байна.	0	Зөвлөмж өгөх	
6	Буянт сумын Соёлын төв нь шинэ байр ашиглалт орсонтой холбоотойгоор 2.3 сая төгрөгийн хандив цуглуулан үйл ажиллагаандаа зарцуулсан ч тайланд тусгаагүй, Зэрэг сумын сургууль нь тэгш ойтой холбоотой 9.9 сая төгрөгийн хандив цуглуулсан ч данс бүртгэлд тусгаагүй байна.	12.2	Зөвлөмж өгөх	
7	Цэцэг сумын Хөшөөт багыг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотойгоор цэцэрлэгийн	0	Зөвлөмж өгөх	

	барилга, цахилгаан хангамж болон гэрэлтүүлэгтэй холбоотой ажлууд, Соёлын төвийн барилга, халуун ус, гүний худаг, халаалтын зуухны барилга, ус түгээх байр 2, цэвэрлэх байгууламж, гадна инженерийн шугам сүлжээний байгууламж, дээрх барилга байгууламж баригдсан газрыг орлогод бүртгээгүй байна. Цэцэг сумын Жижиг дунд үйлдвэрлэлийн сангаас авсан тоног төхөөрөмжүүдийг данс бүртгэлд тусгаагүй байна.			
8	Үйл ажиллагаа нь зогссон "Үенч-Эрчим хүч" ОНӨААТҮГ-ын өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгасан байна.	9.3	Зөвлөмж өгөх	
9	Жаргалант сумын сургууль, цэцэрлэгүүдийн анги танхимуудын дотоод орчны агаарын чанарыг сайжруулах цэвэршүүлэх, дулааны хэвийн хадгалалтыг дээшлүүлэх алдагдлыг багасгах зорилгоор түлш халаалтын зардлаас аймгийн Засаг даргын А/483 тоот захирамжаар Окфил" ХХК-тай 158.8 сая төгрөгөөр гэрээ байгуулсан, гүйцэтгэлээр 1229 ширхгийг 138.8 сая төгрөгөөр нийлүүлсэн нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн	138.8	Зөвлөмж өгөх	
10	Жаргалант сумын сургууль, цэцэрлэгүүд нь тайлант онд үйл ажиллагаа хэвийн явагдаагүйтэй холбоотойгоор түлшний хөнгөлөлт, үр дүнгийн урамшууллыг үр дүнг нь бодитой үнэлээгүйгээс харилцан адилгүй олгосон байна.	0	Зөвлөмж өгөх	
11	2020 онд шүүхийн шийдвэрээр ажлаас үндэслэлгүй халагдсантай холбоотой 16 иргэнд цалинг урсгал төсвөөс олгож, авлага бүртгээгүй, буруутай албан тушаалтнуудаар төлүүлээгүй байна.	117.1	Зөвлөмж өгөх	
12	Зэрэг Шим-Ус, Зэрэг Тээлийн-Илч, Минжит булган хот тохижуулах газар, Үенч Мөнх-Ундарга ОНӨААТҮГ-д нь төлөөлөн удирдах зөвлөлгүй, орлогын доод хязгаар, зардлын дээд хязгаар, орон тоог батлуулан ажиллаагүй байна.	0	Зөвлөмж өгөх	
13	Буянт сумын Соёлын төвд хандиваар хөшөөг хөрөнгийн ангилал буруу бүртгэсэн	15,0	Зөвлөмж өгөх	
14	ЗГ-аас гаргасан 1999 оны 38, 2004 оны 123 тоот тогтоолуудыг зөрчин Цэргийн цолны цалин болон онцгой нөхцөлийн нэмэгдлийг Аймгийн ЗДТГ олгоогүй байна.	4,8	Зөвлөмж өгөх	
ДҮН		1925.5		

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

